

## Енох үхлийг үзээгүй ч итгэл дотор нас барсны учир

Библийн дэндүү олон ишлэлийн дагуу хүн үхэхдээ сэхээгүй болж, үл орших байдалд ордог. Энэ үнэнтэй зөрчилдөх мэт хэд хэдэн Библийн хэсэг бий. Гэтэл Ертөнцийн Эзэн худал хэлдэггүй учраас Үг нь дотроо зөрчилдөнө гэж байхгүй. Энэ бол Библийг тайлах ухааны үндсэн зарчмын нэг юм.

Ямар нэгэн ишлэл дээр Түүний өөр хэсэгт тод үгээр илчилсэн үнэнг эсэргүүцсэн тайлал хийвэл Библийг буруу тайлбарлахад хүрэх нь мэдээж. Бид өмнөх нийтлэлд хэд хэдэн тийм хэсгийг авч үзсэн.



Энэ нийтлэлд онцгойлон “хэзээ ч нас бараагүй” гэдэг Енохын амьдралыг авч үзэх болно.

Енохын тухай Библид бага зүйл байдаг ч тэр нь их сонирхол татам. Енох Адамын долоо дахь үеийн удам бөгөөд Ноагийн буурал өвөө байсан. Тэр үед хүн төрөлхтөн бараг бүхлээрээ Ертөнцийн Эзэнээс урваад байнга л хорон муу юм сэрэн сэтгэж, ёрын мууг үйлдэн гүйцэтгэдэг болсон (Эхлэл 6:5). Ийм үеийнхний дунд Енох харин Ертөнцийн Эзэнтэй хөл нийлүүлэн алхдаг байсан. Эцэст нь Их Эзэн түүнийг “авч явсан учир тэрээр дэлхийд байсангүй” (Эхлэл 5:24; АБ2019). Энэ ямар учиртай вэ?



Еврей эхэнд “дэлхий” гэсэн үг алга. Иймд СМО орчуулгын дагуу Их Эзэн Енохыг “авсан тул тэрээр энд байхаа болив” гэжээ. “Дэлхийд байсангүй” буюу “байхаа болив” гэж орчуулсан еврей үг ер нь “ор сураггүй болсон”, “алга болсон”, “олдохоо больсон”, “үгүй болсон” эсвэл “нас барсан” гэсэн утгатай (энэ сүүлчийн утгаараа Иов 7:8,21, Дуулал 39:13; 103:16; Сургаалт үгс 12:7 зэрэг ишлэлд орсон). Гэвч “Енох үхлийг амсалгүй тэнгэрийн улсад очсон” гэж тайлбарлах нь түгээмэл.

Энэ буруу ойлголт учир битүүлэг бас нэгэн ишлэл дээр үндэслэдэг. Үүнд: “Итгэлээр Енох үхлийг үзэлгүй дээш аваачигдсан. Түүнийг Бурхан авч явсан учраас тэр олдсонгүй. Тэр аваачигдахынхаа өмнө Бурханд таалагдсан гэсэн гэрчлэл хүлээн авчээ” (Еврей 11:5).

Юуны өмнө хэлэхэд, “Түүнийг Бурхан авч явсан учраас тэр олдсонгүй” гэсэн нь Эхлэл 5:24-н грек орчуулгаас нь шууд иш татсан үг (тэгэхээр “дэлхийд байсангүй” гэсэн хэллэгийг “олдсонгүй” гэж орчуулсан).

“Енох үхлийг үзэлгүй дээш аваачигдсан” гэсний хувд грек эхийг нь үзэхлээр, “дээш” гэсэн санаа байхгүй, харин өөр тийш шилжүүлэгдэхийг хэлнэ. Энэ нь “үхэл үзэхгүйн тулд” гэсэн зорилготой нь тодорхой.

Тэгвэл тус ишлэлийг үгчлэн орчуулахаар: “Үхэл үзэхгүйн тулд Енох итгэлээр шилжүүлэгдсэн” гэжээ. Энэ ямар утгатай үг вэ?



Енох нас барсан нь энэ ишлэлийн хам сэдвээс дэндүү тодорхой. «Еврей» захидлын 11-р бүлгийг бүхлээр нь уншвал итгэлийнхээ төлөө Их Эзэний сайшаалыг хүртэн магтуулсан хүмүүсийн тухай. Абел, Енох, Ноа, Абрахам, Сара нарыг нэрлээд “Тэд бүгд... итгэл дотор нас барсан билээ... Итгэлээрээ тэд бүгдээрээ сайн гэрчлэлийг олоод, амлагдсаныг хүлээн аваагүй аж” (Еврей 11:13+39).



### Итгэлийн баатрууд

Өнгөрсөн үеийн тэр бүх итгэлийн баатрууд Их Эзэний амласан зүйлийг энэ насандаа аваагүй нас барсаныг их тодорхой хэлсэн.

“Бүгд” гэдэг үгэнд зүйрлэсэн юмуу шилжсэн утга байхгүй, “бүгд” гэдэг нь нэгийг нь ч орхиж хасалгүйгээр цөмийг нь багтаах утга агуулсан үг учраас Енох яалт ч үгүй “итгэл дотор нас барсан” итгэлийн баатруудын тоонд орно.

Тэгвэл Енох “үхлийг үзэлгүй дээш аваачигдсан” гэдэг нь түүнийг хэзээ ч үхээгүй гэсэн үг лав биш.



Улмаар, Енох Ертөнцийн Эзэнтэй хамт алхдаг байснаас олон мянган жилийн дараа Есүсийн хэлсэн, энэ сэдэвт чухал үгийг мартаж болохгүй.

**“Тэнгэрээс доош бууж ирсэн Хүний Хүүгээс [=Есүсээс] өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч байхгүй”** гэсэн нь маш тодорхой мэдээлэл юм (Иохан 3:13). Үүнээс ч харахад Енох тэнгэрийн улсад ч яваагүй нь лавтай.



Енох “үхлийг үзэлгүй аваачигдсан” гэсний учрыг цааш хөөвөл, «Еврей» захидлын дагуу Енох Ертөнцийн Эзэнд таалагдан Түүгээр “аваачигдах” буюу “шилжүүлэгдэх”-эд хүргэсэн шалтгаан нь яалт ч үгүй итгэлтэй нь холбоотой. “Итгэлгүйгээр таалагдана гэдэг боложгүй юм. Учир нь Бурханд ойртон буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгчдад Тэрээр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” (11:6). Енох Ертөнцийн Эзэнд итгэсэн учраас Түүнд таалагдсан.

Еврей 11:1-н дагуу итгэл гэдэг бол хүлээгдэж буй зүйлийн дагуу явах ба хараахан харагдахгүй зүйлийг гарцаагүй мэдэх явдал юм. Ийм итгэлийн алдартай жишээ бол Абрахам.



Их Эзэн Абрахамыг дуудаж, шинэ нутаг өгнө гэж амлахад Абрахам хэлсэнд нь итгэсэн учраас нутгаа орхиж явсан. Үүнээс гадна Их Эзэн түүнийг үй олон үр удамтай болно гэж амласан. Абрахамын нас явсан ч ганц хүүхэдтэй ч болоогүй. Тэгсэн ч гэсэн олон жилийн турш Их Эзэний үгэнд итгэсээр л байсан бөгөөд эцэст нь хөгшин эхнэр Сарагаасаа нэг хүүтэй болсон.



Ийм итгэлийн бас нэг жишээ бол Ноа. Ноа мөн адил Ертөнцийн Эзэний өөрт нь хэлсэн үгэнд итгэсэн учраас үер болохын шинж нэг ч байхгүй байхад нөгөө алдартай усан онгоцоо барьсан. Их Эзэний үгийг дагасан учраас гэр бүлийнхээ амийг аварч чадсан. Энэ хүмүүсийн жишээнээс дүгнэхэд, итгэл үйлдлээс харагддаг.

Үүнчлэн Енох Их Эзэнтэй алхдаг байхдаа биеллэхийг нь итгэлтэйгээр хүлээх тийм үгийг Их Эзэнээс авсан байж таарна. Тэр нь ямар үг байсны сэжүүр Иудагийн бичсэн захидалд бий. Енох эш үзүүлэгч байсан бөгөөд ирж айсуу шийтгэлийн



талаар Ертөнцийн Эзэнийг үл хүндэтгэн явдаг үеийнхэндээ анхааруулсан гэжээ (1:14-15). Улмаар, Енох хүүдээ “Метусела” буюу “нас барахаар нь илгээгдэнэ” гэсэн утгатай нэр өгөөд ч итгэлээ илэрхийлэв (Лук 3:37). Үнэхээр Метуселагийн нас барсан тэр л онд Ертөнцийн Эзэн усан галав илгээж, муу үйлс хийдэг бүх хүмүүсийг тэр үерээр шийтгэжээ. Метусела 969 нас хүрсэн бөгөөд энэ дэлхийд хамгийн урт насалсан хүн гэдгээрээ алдартай. Өндөр нас нь тухайн үеийн хүмүүст гаргасан Ертөнцийн Эзэний асар их тэвчээрийг батлах бодит илэрхийлэл юм (2 Петр 3:9).

Енох айсуй ирэх шийтгэлийн тухай ярьдаг байсан гэхэд хүмүүс тийм эш үзүүлэгчийг ер нь сонсох дургүй (жишээ нь, Хаадын дээд 22:8). Тааламжгүй мэдээ дуулгахаар нь тэднийг хавчиад, алах нь ч түгээмэл байжээ (Нехемиа 9:26; Үйлс 7:52). Енохын үеийнхэн ямар хүмүүс байсныг санавал тэдэнд шийтгэлийн тухай анхааруулах нь Енохын хувьд өндөр эрсдэлтэй үүрэг байсан нь гарцаагүй. Тэд Енохыг цааш нь харуулахаар оролдох нь энхүүхэнд гэсэн үг. Тэгвэл Енох маш их хавчлага дундуур явсан нь эргэлзээгүй.

Энэ бүх зүйлийг эрэгцүүлэн бодохоор, Еврей 11:5 нь Ертөнцийн Эзэн Енохыг алуулах “үхэл үзэх”-ээс хамгаалах гэж аюултай байдлаас гэнэт өөр тийш нь аваачсан тохиолдлыг ярьсан байж болно. Тийм бол Ертөнцийн Эзэн түүнийг “аваад явсан” гэдэг нь өмнөх нийтлэлд авч үзсэн Елиаг хуй салхи,



Филипийг Ариун Сүнс гэнэт аваад явсантай адил бөгөөд ижилхэн үр дүнтэй байсан гэсэн үг. Елиша Елиаг дахин харсангүй, тайган Филипийг дахин олж хараагүй. Үүнчлэн Енох үеийнхэндээ “олдсонгүй”.

Гэтэл үхлээс нэг аврагдах нь хэзээ ч үхэхгүйг хэлээгүй нь мэдээж. Ноа усан онгоц барьж, өөрийн ба гэр бүлийнхээ амь насыг үерт живэх үхлээс аварсан хэдий ч, дараа нь тэд бүгд нас барсан (Эхлэл 9:29; 11:11). Үүнчлэн

Енох нэг үхлээс аврагдсан боловч эцэстээ 365 настайдаа нас эцэслэсэн (Эхлэл 5:23).



Эхлэл 11:5-т Бичвэр чухам хэний үхлийг хэлж буйгаа тодорхойлоогүй учраас Енохыг “үхэл үзэхгүйн тулд аваад явсан” тал дээр бас өөр боломжийн тайлбар бий. Их Эзэн усан галавт живэх гэж буй үй түмэн олон хүн амьтны үхлийг Еноход үзүүлэхгүйн тулд түүнийг эртхэн “энэ дэлхийгээс авч явж” нас эцэслэхэд хүргэсэн байж болно.



Енох итгэл дотор нас барсан нь • 8

Өвөг дээдэс нь ба ойрын үр удамтай нь харьцуулахад Енох хамгийн бага насалсан хүн байсан нь энэ тайлбарыг дэмжинэ (Адам 930; Сет 912; Енош 905; Кенан 910; Махалалел 895; Иаред 962; Енох 365 !; Метусела 969; Ламех 777; Ноа 950).

Бүтээлээс	НАС	Адамын эриний он
<b>БҮТЭЭЛ</b>		<b>ҮЕР</b>
ADAM 0	930	930
SETH 130	912	1042
ENOS 235	905	1140
CAINAN 325	910	1235
MAHALALEEL 395	895	1290
JARED 460	962	1422
ENOCH 622	365	987
METHUSELAN 687	969	1656
LAMECH 874	777	1651
NOAH	1056	950 2006

Нэгэнт “Енох үхлийг үзээгүй” гэсэн үгийн тайлал тодорхойгүй учраас түүний үхсэн үхээгүйг үхлийн тухай маш тодорхой өөр олон Бичвэрийн үгээр дүгнэх нь ухаалаг хэрэг. Тэгвэл Енох бусад итгэлийн баатрын адил “итгэл дотор нас барсан билээ... Итгэлээрээ ... сайн гэрчлэлийг олоод, амлагдсаныг хүлээн аваагүй” гэж тодорхой хэлжээ (Еврей 11:13+39).

Библийг Библиэр тайлах гэсэн зарчмыг дагая. □

*Дараагийн нийтлэлд үхлийн үнэний тухай мэдэх нь ямар ашиг тус үзүүлдгийг авч үзэх болно. Юуны өмнө энэ нь таны аврагдах дараалалд нөлөөлж мэднэ!*



Енох итгэл дотор нас барсан нь • 9

### Хэрэглэсэн эх сурвалж:

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Gill, J. (1763). *Exposition of the Old and New Testaments*.

<https://www.biblestudytools.com/commentaries/gills-exposition-of-the-bible/>

---Монгол Хэлний Их Тайлбар Толь (2016). mongoltoli.mn

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). *Strong's exhaustive concordance of the Bible* (with Greek and Hebrew Lexicons). [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)